



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/11

Номгон

Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн
тоо бүртгэлийг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалаар батлагдсан "Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам"-ын 3.1, 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Агаарын бохирдлын эх үүсвэрийг нэгдсэн тоо бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Ганзориг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

С.Рэнцэндагва Татварын хэлтсийн дарга

Н.Энхжаргал Эрүүл мэндийн газрын дарга

Ж.Алтангэрэл Онцгой байдлын газрын дарга, Хурандаа

С.Амармөнх Баянхонгор аймгийн Авто тээврийн төвийн дарга

Д.Батзаяа Цагдаагийн газрын дэд дарга, Цагдаагийн дэд хурандаа

Б.Намуун Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Б.Бадамцэцэг "Баянхонгор эрчим хүч" ЦТ ХХК-ний Ерөнхий инженер

Ц.Гүрэвсүрэн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны хяналтын Улсын байцаагч

Б.Сэвжиддулам Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

Сумын Засаг дарга, Байгаль орчны хяналтын Улсын байцаагч, Байгаль хамгаалагч нар

Нарийн бичгийн дарга:

Ч.Оюунчимэг Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга

842311975

2. Агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл тооллогыг журмын дагуу үр дүнтэй зохион байгуулж, тоо бүртгэлийн дүнг нэгтгэн боловсруулж 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн дотор Цаг уур, орчны шинжилгээний газарт хүргүүлж ажиллахыг Ажлын хэсэг (Э. Ганзориг)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т. Хишигбаатар) -т даалгасугай.

ДАРГА  Д. МӨНХСАЙХАН